

### С. ЭРДЭНИЙН ӨГҮҮЛЛЭГИЙН ТУУРВИЛЗҮЙН ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ТУХАЙД

До. Цэнджав<sup>1</sup>

#### С. Эрдэнийн уран зохиолын ертөнцийг үзэх үзэл

Зохиол бүтээлийн үнэт зүйлсийг цаг хугацаа шалгаж, заримыг бүдгэрүүлж, нөгөөг тодруулж, бүр нэг хэсгийг ул мөргүй болтол үгүйсгэдэг хатуу чанга хуультай ажээ. Нийгэм яаж ч өөрчлөгдөхөд жинхэнэ зохиол туурвил өөрийн чансаа, үнэлэмж, үнэ цэнээ хадгалж, харин ч түүнээс дахин дахин шинэ нээлт, гаргалгаа хийж судалгааны эргэлтэд орж, хүмүүсийн шохоорол сонирхол буурахгүй улам үнэ орсоор байдаг байна. Тухайн нийгмийг аялдан дагасан, улстөржсөн, түүхэн хүнийг хэтэрхий магтан дуулсан зэрэг цаг үеийн захиалгын шинжтэй зохиол бүтээл он цагийн шалгуурт өртөж, зохиолч, зохиол хоёуланг нь цагийн урсгалд живүүлдэг жамтай байх юм. Урт настай эдэлгээтэй бүтээл туурвина гэдэг бол аль ч цаг үеийн шалгуурын дэнсэн дээр тавихад “жингээ алдахгүй” хувиршгүй, өөрчлөгдөшгүй, хасагдашгүй чанарыг өөртөө хадгалдаг. Зохиол бүтээлийн үнэлгээ, үнэт зүйлс хоёр бие биеэ нөхцөлдсөн төстэй зүйл ч гэлээ үнэлгээ нь үнэт зүйлсийг тэр болгон бий болгож чаддаггүй учраас олон алдар гавъяатай зохиолчийн бүтээл хувиршгүй үнэт зүйлсийг бүтээж чаддаггүй болох нь танигдлаа.

Тэгвэл Монголын үргэлжилсэн үгийн зохиолын сод төлөөлөгч, Ардын уран зохиолч Сэнгийн Эрдэнэ хэмээх энэхүү зохиолчийн уран бүтээлийн үнэлэмж, үнэт зүйлс нь хуучин нийгэм бүхлээрээ солигдсон өнөө цаг үед ч ач холбогдолтой хэвээрээ төдийгүй, ирэх цагийн өнгөнд ч үнэ цэнээ хадгалах тийм дархлааг тогтоож чадсан нь зохиолчийн суу билгийг илтгэж байгаа хэрэг юм. Учир нь С.Эрдэнийн ертөнцийг үзэх үзэлтэй холбоотой. Хэдий хатуу чанга хяналттай нийгэмд амьдарч байсан ч гэлээ зангарагтай томхон уран бүтээлчийн хувьд бие даасан, чөлөөт сэтгэлгээтэй, үзэл сурталд баригдаагүй, өөрийн гэсэн дотоод ертөнцтэй, жинхэнэ “урлагийн төлөө урлаг” гэх зарчмыг баримталдаг байсанд зохиол бүтээлийнх нь хамаг үнэт зүйлс оршино. Оросын болон дэлхийн сонгодог зохиолыг гүнзгий судалж, ерөөс зохиол бүтээл “Ийм л байх жамтай юм байна” гэдгийг итгэл үнэмшил болголоо шингээж авсан төдий л олон биш зохиолчийн нэг байлаа. Уншиж гэгээрэх, ургуулж бодох, амьдралыг амтлах, жаахан олзыг том болгож үсэргэх, хөдөөгийн ахуйлаг амьд үг хэллэгийг өөрийн үгийн сан хөмрөг болгох, байгаль болоод хүмүүний амьдрал ахуй орчинг “дотор нь ороод гарсан” юм шиг мэдрэх нь хүүрнэл зохиолчдын гол амин сүнс байдаг. Нийгмийн захиалга, шаардлагаар бус, цэвэр өөрийн зүрх сэтгэлдээ захирагдан, жинхэнэ цэвэр

<sup>1</sup> Доктор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

уран бүтээлчийн жам ёсоор зохиолоо туурвиж чадсан учраас өнөөдөр эл уран бүтээлчийн бүтээл үнэт зүйлсээ алдалгүй үлдээж чадсанд хамаг учир холбогдол байна. Шуудхан хэлбэл, зохиолч өөрөө урлагийн гоо сайхны мөн чанар, өнөд удаан хадгалагдах мөнхийн хуулийг илүү гүнзгий ойлгосны зэрэгцээ жинхэнэ уран бүтээлч хүний заяагдмал шинж, төрмөл зан араншин, оюуны соёл боловсрол, бясалган эргэцүүлэгч мэдлэг чадвар нь аясыг дагах биш, зохиолчийн зүрх сэтгэлээр сөрөх үзлийг төлөвшүүлсний хүчинд өөрийгөө он цагийн салхинд авч гаран “урлагийнхаа гэрээ” бүрэн бүтээл авч үлдэж чадсан болов уу?

Хүн нийгмийн бүтээгдэхүүн болохоор хатуу хариг цаг үеийн захиалгыг сөрнө гэдэг хэцүү. Түүнийг Р. Чойном шиг хуучин нийгмийн эсрэг ганцаараа босож, бузар булай бүхнийг өөд уруугүй эсэргүүцэн шүүмжилж, хэнээс ч айлгүй тэрсүүд үзэл гаргаж байжээ гэвэл магадгүй зөвшөөрөх хүн гарахгүй бизээ. Гэхдээ зохиолч С.Эрдэнэ элдвийг үзэж, юмны цаад наадахын учрыг эртхэн олж ширээж тунгаасан сэхээтний ёсоор “Зохиолч яруу найрагч нийгэмд үйлчлэгч биш, харин оюун санаа, далд ертөнцийн мөнхийн гоо сайхан, уран бүтээлийн үнэ цэнийг бүтээгч” гэдгийг ойлгож түүнээ зохиол бүтээлдээ шингээн харуулж чаддаг байжээ.

Ухаан авъяас, ур чадвар, зохиол бүтээх сонгодог арга барилын хувьд давалгаа үүсгэж, нийгмийн харилцаанд шүүмжлэлтэй хандаж байснаас түүний бүтээлийг ил далд аргаар зэмлэж, өөлж, сэжиглэж, гоочилж байв. Дотоод яамыг гутаадаг, “Тоогийнд өнгөрүүлсэн нэг өдрийн” Тоо гэдэг бол Товчоо гэсэн үг үү?, сунагар хар машин гэж хэнийхийг хэлэв? зэргээр оролдож байсныг зарим зохиолч дурсан ярьсан юм. Хэдийгээр нэр алдарт хүрч байсан ч, тухайн нийгмийн үзэл сурталтай мөргөлдөж, хэлэх гэснээ бүтээлээрээ дамжуулаад түнших мэт битүүхэн хэлчихдэг, дүрэлзсэн биш мөртлөө яггүй үндэсэрхэг тэрсдүү үзэлтэн байсныг өнөөдрийн түвшингээс харахад илхэн байна. Нэн ялангуяа гучаад оны хэлмэгдлийн тухай үе үе харамсан цухалзуулж, хэний ч хэлж чадахгүй зүйлийг эвлэгхэн нухацтай илэрхийлж, энэ сэдвийг насан туршдын бүтээлийн чухал чиглэл болгосныг тэмдэглэх нь зүйтэй. Хэрвээ уран бүтээлийн чөлөөт байдал, чөлөөт урсгал чиглэлийг хагас дутуу ч гэсэн хүлээн зөвшөөрч байсан бол энэ зохиолч залуу эрчтэй үедээ өнөөдрийнхөөс илүү гайхамшгийг бүтээх байжээ гэсэн халаглал судалгааны явцад өөрийн эрхгүй төрж байв.

Эерэг дүр, сайн талын баатар, нийгмийн шинэ хүн, бүтээн байгуулагч шинэ хүн, үлгэр жишээ дуурайлалт дүр зэргийг зохиолчдын их, бүгд хурлаараа дэвшүүлж, ингэж бичихийг зохиолчдоос шаардаж, уриалж “зөрчилгүйн онол” ноёрхож байсан тэр цагт л гэхэд С.Эрдэнэ үүнийг сөрөх мэт “Жаргал даахгүйн зовлон” туужаа бичсэн байх юм. “Уран зохиол бол цаг хугацааны урлаг” гэсэн онолын эсрэг зохиолч яагаад тухайн нийгэмдээ адрах болов? Хөдөлмөрийн алдартай хүн, гэр бүлийг яагаад сөрөг талаас нь харуулав? зэрэг асуудлууд ар араасаа тавигдсан тэр үед амьдралыг олон талаас нь харцгаая, зохиолч хамгийн эгзэгтэй хурц асуудлын гол цөмд байх ёстой юм биш үү? гэсэн чангахан асуултыг нийгмийн өмнө даацтай тавьж чадсан байна.

С.Эрдэнэ уран зохиол, урлагийн мөн чанар, ёс зүй, хууль тогтолцоог ойлгосон хэрсүү бодолтон болохынхоо хувьд няцаагдашгүй үнэнийг тулган тавьдаг байна. Түүний дээрх кино тууж болоод бас бус зохиолыг гуйвуулан хөрвүүлж, “Ёс сурталгүй” болгох” гэсэн аймшигт нэр хаяг хүзүүнээс нь зүүхэд ойрхон байсан ч гэлээ зохиолчийн илүүрдэх, илбэдэх мэт ур чадвар, мөн уншигч олонд хүндлэгдсэн нэр төр, бичиг номын билгүүн ухаанаар аливаа шийтгэл оногдлоос үлдчихээд байдаг байж. Атаархал,

жөтөөрхөл, дайсагнал, учир утгагүй яриа хэл ам, дайрлага давшлага байгаагүй юу? гэвэл байхын хэмжээгээр байж. Гэвч яаж ч дийлээгүй нь жинхэнэ уран бүтээлчийн хийж чадах, бас чамгүй ухаалаг үгээ хэлж, сөрж зогсож чадах тэрхүү ноён нуруутай холбоотой. Ерөөс хүнд суртал, захиргаадлыг таашаадаггүй шударгуу зан чанартай байсныг Ардын уран яруу найрагч Ш.Сүрэнжав гуай саяхны дуртгалдаа бичсэн байна лээ. Жаахан халамцуудаа онгоцонд суунгуут өөрсдийг нь удирдаж явсан лут амьтанд “Чи муу Майдар хэн юм бэ?” гэж хашгирсан гэж бичсэн байсан. Тэр үед жижиг амьтнаас гарахааргүй үгээ. Энэ бол тохиолдол гэмээр жаахан зүйл зүйл боловч сэтгэлийн доторхи шарх зовиураа нууж чадалгүй, гарган гарган алдаж байсны түүний намтар судлалд хамааралтай, бүрхэгийг тодчилж болох уугисан галын нэгэн энгийн жишээ. Ард түмний зовлон зүдгүүр уран бүтээлчийн зүрх сэтгэлээр дайрч өнгөрдөгийн жамаар тэр эгэл жирийн хүнийг өмгөөлөгч, өрөвдөн хайрлагч тэднийг хүндэтгэн бишрэгч байсан нь зохиол бүтээл болгоноос тодорхой харагддаг.

Хөдөлмөрийн баатар байтугай, жирийн ажилчин хүнийг ингэж бичвэл, доог тохуу хийлээ, үлгэргүй, үзэл сурталгүй ёс бус юм бичлээ гэсэн зэмлэл хүлээдэг байсан цаг. Гэтэл эхнэрээ хөдөлмөрийн баатар болсон сургийг нууц амрагийнхаа халуун өвөрт сонсоод “үхсэн хойноо” гэж хэлж чадаж байна. Бас болоогүй архи уун согтуурч, үлгэр жишээ байх ёстой гэр бүлийн хүн морины дөрөөнд чирэгдэн үрэгдэж байгаа тухай гардаг. Ийм ёс зүйгүй, булай явдал гэж байхуу? Агуу үлгэр жишээ, хөдөлмөрийн хүний бахархал болсон баатар хүний нөхөр...Даанч яваа? гээд л гасалцгааж байсан. Бүхэл бүтэн хөдөлмөрийн баатрын дэргэд, тийм гэр бүлд ийм ёс зүйгүй, ийм үзэн ядмаар, ийм зүй бус амьдрал байж болох уу даа. Энэ бол тухайн үеийн уран бүтээлд тавьдаг цаг үеийн гаслант цалам, гамшигт шаардлага. Гэвч яргамал уран бүтээлчийн нүд өөрөөр харж, амьдралын үнэнээс ч урваагүй юм. Учиртай тохуурхал, ёжтой сануулга, ухаалаг эсэргүүцлээс гадна зохиолч өөрөө хэн бэ? гэдгээ харуулсан бардамнал байлаа.

Зохиолч С. Эрдэнэ хуучин тогтолцоот нийгмийн бүтээгдэхүүн мөн боловч миний ажигласнаар түүний бүхий л өгүүллэгт аялдан дагалдсан, уриалж лоозогносон, ухуулж сэнхэрүүлсэн, туйлширч хэтрүүлсэн зүйл ажиглагдсангүй. Социалист үзэл суртлын уриа лоозон, ухуулах хуудас нялзаж наалдаагүй, ийм өнгө аяс ер шингээгүй, цэвэр амьдрал, цэвэр урлаг гэсэн ойлголтод л хамаарагдаж байсныг ажиглаж болох юм. Үнэнийг хэлж чадна гэдэг бол аль ч цагт бүх үнэт зүйлсийн дотроос хамгийн гайхамшигт үнэ цэн юм.

Энэ чанараараа уран бүтээлч өөрийн бие даасан, чөлөөт сэтгэлгээний үзэл бодлын үнэт зүйлсээ тууштай хадгалж, социалист реализмын тулгуур гол шаардлагуудыг авч хэрэглэхгүй тийм баригдмал хэв загварчлалаас зайлсхийснээрээ Монголын шинэ үеийн уран зохиолд **“Эрдэнийн загварчлалын гэж болох сонгодог реализмыг”** бий болгожээ гэж дүгнэж болохоор байна. Социалист реализмын нэгэн зэрэг боломж бололцоо болох дотоод үр хөврөлд орших зөрчилт байдал, учир шалтгаалцлын харьцангуй чөлөөт сэтгэмж болох романтизм, сентиментализм, зөн билэг, эссе эргэцүүлэл, символист хандлага гэж болохоор онол практикийн шинжтэй зүйлийг ашиглаж байснаараа бусдын адил “нэг цонхоор” харж байсангүй. “Диваажинд хүрэх оньс” өгүүллэгийн төмөр оньст тэрэг хийхийг санаархагч Жамбал өвгөн бол нэгэн бодлын “монгол Дон Кихот” бөгөөд цэвэр монгол романтизм юм. Социалист реализм нийгмийн дайчин идэвхтэй, дагуулагч ангич намч чанарыг харуулсан ямар ч өө сэвгүй дүрийг шаарддаг бол С.Эрдэнэгийн өгүүллэгийн дүрүүд жинхэнэ сонгомол уранзохиолд буюу амьдралын өөрчлөшгүй хуулинд захирагдсан хиймэл биш, ялигүй

гөжүүд, өөрийн үгтэй, гял цал юмгүй борог маягийн дүрүүд юм. “Өвгөцүүл” өгүүллэгийн өвгөн Гонгорын дүр социалист реализмын ердөө сөргүүлж тавьсан дүр болсон гэж болно. Нутаг, нугын хэдэн өвгөн нийлээд Балж голынхоо тулыг барихаар сааль бэлтгэж, түүнээ зараад нэгдэлдээ тэрэг авч өгөхийг санаархдаг. Үүнийг өвгөн Гонгор зориуд тасалдуулж байна. Багийн дарга хийж явсан тухайн нийгмийн “улаан идэвхтэн” гэмээр дарга (бурхан шашинд чин сүжигтэй. До.Ц) тээр “...Сүжиг шүтлэгтэй гэж шоглох, ад үзэх санаатай бас. Би яахыгаа одоо болсон хойно хүнээр заалгах уу? Ертөнцийн амьтны заяа нэг гэж би ойлгосон хэвээрээ шүтдэг бурхандаа шүтээд л дуусна. Цөлмөгчдийн шээс асгаснаас бурхдын шавдан асгаж явбал жаргалын дээд” гээд өвгөдийн бодлыг сөрөн гөжүүдэлж шөнө харанхуйд нууцаар загас агнуурын хаалтыг задалж, голынхоо загасыг аварч байдаг. Бурхан шашиныг үзэн ядаж байсан тэр цагийг хэрэндээ “ялласан” явдал байлаа. Энэ мэтийн жишээг цөөнгүй дурдаж болно.

Тэр өгүүллэг бичиж эхэлсэн жараад оноос эхлээд л энэ зарчимдаа үнэнч явж монголынхоо хөдөө нутгийн зон олон, өвгөд, үндэсний зан заншил, монгол хүний зан араншин, морь мал, хэлмэгдэл, байгаль, эгэл жирийн хүмүүсийн харилцааг нээн харуулсан учраас түүний өгүүллэгүүд үзэл суртлаас ангид болгож, улмаар түүний зохиолын үнэ цэнийг өргөж байна.

### **Уран бүтээлийн үнэт зүйлс ба С.Эрдэнийн өгүүллэгийн туурвилзүй**

Ер нь уран бүтээлийн үнэт зүйлс гэж юу вэ? Туурвилзүйн онолын эцэг Аристотель туурвилзүйд ариутгахуй, танихуй, гоо сайхан гэсэн ойлголтуудыг онцгойд авч үзэж, энэ нь чухамдаа тухайн бүтээлийн амин сүнс, үнэ цэнтэй зүйл болохыг зуун, зуунаар дамжих он жилүүдийн цаана дэвшүүлсэн тавьсан байна. “Урлаг бол хүн ур ухаанаараа бүтээгээд эх дэлхийдээ нэмэрлэсэн анхны бүтээл, дэлхий дээр уг байдлаараа байхгүй шинэ зүйл” гэж Платон үзсэнийг үнэт зүйлсийг үлдээхтэй холбож үзэж болохыг бас дурдалтай. Уран бүтээлийн үнэт зүйлс гэдэг нь чухамдаа алт хэмээх өнгөт металл шиг хэзээ ч чанар чансаа үнэлэмжээ алдахгүй, цагийн сорилт шалгуурыг давж, уран сайхны ид шидээ мөнхөд хадгалж, хожим үеийнхэн түүнээс суралцах өв болтлоо баталгаажиж дархлаажсан үнэмлэхүй дээд хэмжүүр гэж болно. Өөрөөр хэлбэл, утгазохиолын хүрээллийнхэний хүлээн зөвшөөрөгдсөн гоо сайхан юм. Үнэт зүйлсийг урвуулж хөрвүүлж үл болно, үнэт зүйлийг гуйвуулж мушгиж үл болно. Ийм байдлыг эсэргүүцэх, хамгаалах дотоод мөн чанар тухайн бүтээлд амин сүнс мэт гүн хадгалагдсан байдаг.

С.Эрдэнийн өгүүллэгүүдийн үнэмлэхүй үнэлгээ нь үл хувьсах чанар, уусах үрэгдэхгүй яс даац, бусдын бүтээлд нөлөөлөх сэхээрэл ухаарал, амьдралын далд чанарыг нээсэн эх болсон байгалиар шимт хөрсөө суулгасан гүн ухаан юм. Нэртэй зохиолч уран бүтээлчид тодорхой хэмжээгээр үнэт зүйлсийг үлдээдэг боловч эрдэмтэд, судлаачид, шинжээчид, уншигчид бүгд хүлээн зөвшөөрөхөөс аргагүй байдалд хүрсэн тийм үнэт зүйл элбэг тохиолдоод байдаггүй бололтой. Харин Сэнгийн Эрдэнэ хэмээх энэхүү өгүүллэгчийн бүтээл туурвилын ур чадвар, нээлт шинэчлэл, гүн ухаан, уран сайхны дүрийн хөгжилд үлдээсэн өв соёлыг яаж ч өөр өөрсдийнхөөрөө тайлбарлалаа ч гэсэн үнэ цэн нь их савны ёроолд тунах мэт үлдэж хэв янзаараа, залуу эрүүл чийрэг тэр байдлаараа үлдэх болно. Энэ бол үнэт зүйлсийн баталгаа, нотолгоо юм. Уран бүтээлчийн хувийн амьдрал, зан араншин, хувийн үзэл бодол, маргаан тэмцэл, хэн нэгэнд эвгүй хандсан хандлага, маргаантай зөрчилт байдал зэрэг нь ерөөс томоохон уран бүтээлч, зохиолчид байдаг ердийн зүйл бөгөөд үүнийг уран бүтээлийн үнэ цэн, чанар ханшид нөлөөлөх шалтаг шалтгаан болгох ёсгүй.

Миний бие дунд сургуульд байхаасаа уншсан, хэний ч үнэлж хэлдэг тэр зүйлийг давтахыг хүсэхгүй байна. Юм болгон дээр түүний өгүүллэг бүрийг авч үзээд баталж нотлохыг ч хүсэхгүй байна. Магадгүй энэ бол судалгааны нэлээд хуучирч байгаа арга хэлбэр байж магадгүй. Зохиолч гэж хэн байв, түүний бичлэгийн арга техник, өгүүллэгийн бүтэц зохион байгуулалт, агуулга хэлбэр, хэл найруулга, сэтгэлгээ нь юу байв? гэдгийг хам бүтэц, цогц байдлаар утгын мөн чанарыг шинжилдэг герменетикийн аргыг туршин тэрхүү зүй тогтлыг авч үзэхийг хичээлээ.

Алив нэгэн дурын бодис дээр нөгөө бодис нэмэхэд огт өөр урвалж үүсдэг бол зохиолчийн туурвилзүй зүй дээр цаг хугацаа гэдэг зүйлийг хамааруулж урвалд оруулахад түрүүчийн үнэлгээ огт өөрчлөгдөхгүй байгаа бол тэр үнэхээр сод ховор авъяастан, ачаа даах сонгодог зохиолч болох нь аяндаа тодорно. Хэдэн мянган жилийн өмнөх Шекспирийн жүжгүүдийг үгүйсгэх нь бүү хэл, дэлхийн шилдэг найруулагч бүр өөр өөр талаас нээлт хийж дөнгөж өчигдөрхөн бүтээсэн мэт шив шинээрээ л хүмүүст таашаагддаг агуу их урлагийн бүтээл туурвилын алт адил үнэ ханштай гэдэгтээ холбоотой.

Уран бүтээлийн үнэт зүйлийг, ер нь сонгодог бүтээл туурвилын үнэт зүйлийг авч үзэхдээ **нээлт, шинэчлэл, үзэгдэл** гэсэн давын өмнө гурван ойлголтыг авч үзэх шаардлагатай болов уу? Бид зохиолчийг монголдоо урамшуулж, шагнахын зэрэгцээ ур чадварыг дэлхийн жишигт гарган зөв зүйтэй даацтай үнэлж чадаагүйгээс болоод их утгазохиолд болоод туурвин бүтээгчийн хувьд үнэхээр харамсалтай зүйл болдог байна. Манай эрдэмтэд, судлаачид нээлт, шинэчлэл, үзэгдэл гэдгийг дурьдаж байсан ч тайлбараас аль болохоор зайлсхийж ирсэн нь тухайн нийгэм хувь хүн, нэг хүний үүргийг хэт дөвийлгөхийг буруушааж байсан хандлагатай холбоотой байж болох юм. Миний бодлоор бол, цоо шинэ орон зайд урд өмнө хэний ч хийгээгүй, давтагдаагүй зүйлийг бүтээсэн шинэ бололцоо, шинэ арга зам, шинэ арга техникийг бий болгохыг **нээлт** гэж болох бол, уламжлалыг өөрчилж хувьсгасныг **шинэчлэл**, хэнд ч мэдрэгдэж танигдахаар хором эгшин зуур оргилж дэлбэрэх явцыг **үзэгдэл** гэж болох бол энэхүү эрхэмсэг дээдийн дээд шалгуурыг нэгэн зэрэг хангах уран бүтээлч ховорхон бөгөөд миний энд ярьж буй тэр хүний бүтээлтэй хамааралтай санагдана. Иймийн тул Сэнгийн Эрдэнэ бол Монголын шинэ үеийн уран зохиолд нээлт хийж, шинэчлэлийг авчирсан, урансайхны сод гарамгай үзэгдэл болох агуу их Д.Нацагдоржийн үргэлжлэл юм. С.Эрдэнийн мэдрэмж, оюун тархины сэдэлтийн шинэ шинэ сэргээлт, дүрслэн үзүүлэх хязгааргүй боломж, байгаль нийгмийн зүй тогтлыг танин мэдсэн гүн ухаан зэргээрээ “Түрүү ургасан чихээс хожуу ургасан эвэр” гэдэгчилэн хэтрүүлэлгүй үнэлж үзвэл, өмнө гарсан бүх зохиолчдын өгүүллэгүүдийг хамаагүй ард орхижээ. Түүний ийм өндөр чадамжийг “Малын хөлийн тоос”, “Наран тогоруу”, “Хулан бид хоёр”, “Түймэр”, “Өвгөцүүл”, “Өвгөн бүргэд”, “Өвгөн хүн чулуу”, “Халуун өдөр”, “Шар навчны халуун” зэрэг зарим өгүүллэгийн ур чадвар харуулдаг. Зөвхөн өгүүллэгийн хувьд тэр шүү дээ.

С.Эрдэнийн өгүүллэгийг судлан үзвэл, жар, далаад он бол түүний өгүүллэг туурвилын үнэхээр оргил үе юм байна. Түүнээс хойш залуу идэр насны цээжний гүнд цохилох халуун гоё дурсамж, эргэцүүлэл оршсон уянгын бичлэгээс татгалзсхийж, амьдралыг танисан ухаарал гүн бодрол тийш шилжсэн байна. Бас кино зохиол, роман зэргийг туурвисан учир өмнөх бичлэгийн өнгө аяс өөрчлөгдсөн нь ажиглагдана. Энэ нь өөрийгөө нэгэн хэв загварт баригдахаас зайлсхийсэн шинэ сорил, шинэ хоёр дахь гараа гэж болно.

Уламжлал шинэчлэл байнга эсрэгцэн зөрчилддөг зүй тогтолтой ч гэлээ өмнөхөөсөө суралцаагүй, түүний дам нөлөөгөөр өсөж өндийгөөгүй, үгүй ядаж нэгэн ухаарал сэрэмж аваагүй нэг ч зохиолч байхгүй нь үнэн юм. С. Эрдэнийн уран бүтээлийн өсөлт, хөгжилтөд илэрхий хүчтэй нөлөөлсөн зохиолчид гадаадаас юуны түрүү ЛН. Толстой, АП. Чехов, Ф.М. Достоевский, М. Булгаков зэрэг сонгодог зохиолчид бол монголоос их Д.Нацагдорж гэдэг нь ерөнхий орчил герменевтикийн оношлуураар нь авч үзвэл хурууны өндөгөнд имрэгдэх мэт тодорхой мэдрэгдэж байна лээ. Зохиолч өөрөө ч энэ тухай дурдан хэлж байж. “Миний өд сөд ургаж эхэлсэн тавиад онд монголын үргэлжилсэн үгийн уранзохиолд Д.Нацагдоржийн үүсгэж өгсөн реалист өгүүллэгийн уламжлал байр сууриа эзлээд хөгжил бадралын ид үедээ орсон шиг санагддаг. Замаа зөв олоход минь хэн тусалж, юу түлхсэн хэрэг вэ? гэж өөрөөсөө асуугаад Дашдоржийн Нацагдоржийн өгүүллэг, цаг үе хоёр гэхэд болно” гэж хэлснээс ч үзсэн тодорхой байна.

Жараад оны яруу найрагт Бэгзийн Явуухулан шинэчлэл хийсний нэгэн адилаар өгүүлэлт зохиолын богино хэмжээний төрөл зүйлд Сэнгийн Эрдэнэ шинэчлэл хийж, урлахуйн их өв хөрөнгө, сан хөмрөгийг хойч үедээ үлдээж, өөрийн уран бүтээлүүдийн үнэт зүйлсийг бий болгосныг дахин тэмдэглэх нь зүй.

Монголын шинэ үеийн уран зохиол Д.Нацагдорж, С.Буяннэмэхийн үеэс ид хүчээ авч хөгжиж байсан үед буюу гучаад оны дундуур улстөрийн хэлмэгдэл эхэлж олон зохиолчийг хэлмэгдүүлж, заримынх нь хийх бүтээх зүрх зоригийг сүрхий мохоожээ. Энэ аймшигт хэрэг явдал манай уранзохиолын хөгжлийг дор хаяж арваад жил сааруулж, оюун санааны үлэмжхэн үнэт зүйлийг үгүй болгон бусниулсан юм. Уранзохиолын хөгжилд бүхэл бүтэн арваад жил байтугай нэг хоёр жилийн “оюуны алдагдал” ч нөхөж болшгүй зүйл гэдэг нь тодорхой. Гэвч авъяас билэг хэзээ ч алга болдоггүй, авъяастныг хэзээ ч устгаж чаддаггүйн хуулиар дөчөөд оны дундаас Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ч.Лодойдамба зэргийн бичгийн мэргэд төрж, өмнө гарсан хоосон орон зай, ангалыг нөхөн төлжүүлсэн бүтээлүүдийг гаргасан юм.

Утга зохиол судлаач, эрдэмтэн Ч.Билэгсайханы дүгнэснээр “Хүүрнэл зохиолд удтал хадгалагдаж байсан ухуулгын аяс, сургамжлах хандлага хоёрыг зоригтой нээж жинхэнэ авъяас билэг, уран сэтгэмж дүрээр сэтгэн дүрслэн зураглаж бүтээдэг урансайхны үнэт чанар бүхий туурвилыг бүтээх туршлага үлдээсэн явдал юм. Ялангуяа С.Эрдэнэ Монголын хүүрнэл зохиолын богино төрөл өгүүллэг туурьт хүний сэтгэлзүйн хувирал хөгжил, амьд төрхийг гаргахад шинэчлэл хийсэн юм” гэж дүгнэсэн нь нүдээ олсон чухал үнэлгээ байлаа. Бас манай нэртэй судлаач, эрдэмтэн С.Лувсанвандан “С.Эрдэнийн “Хулан бид хоёр”, “Хонгор зул”, “Малын хөлийн тоос” зэрэг уянгалаг өгүүллэг өвөрмөц үзэгдэл болжээ” ( Монголын орчин үеийн уран зохиолын онол, түүхийн асуудалд. 1973. 222-р тал ) гэж үнэлжээ.

#### **Уран зохиолд гаргасан шинэчлэл**

Сэтгэлзүйн нарийн үзэгдлийг дотоод сэтгэлийн хөг аялгуутай хослуулж, хүний сэтгэлийг гижигдэн хөдөлгөх аядуу намуун хөг эгшиглэнтэй ховорхон урлах арга барилыг нээж чадсан зохиолч бол Сэнгийн Эрдэнэ байлаа. Энэ чанараараа “уянгын” өнгө, уянгын халил, уянгын мэдрэмж, уянгын сэтгэхүй, уянгын шившлэг, уянгын зураглал, уянгын хөгжимлэг туурвилыг бий болгож, хуучны тайлагнан тоочих, хялбарчлан тодорхойлох, хэт тоймлох, хөгжил хөдөлгөөнгүй уйтгартай болхи бичлэг, зөрчил хувьсалгүй дүлий байдлыг шинэчлэн өөрчилөхөд гол хөдөлгөх хүч болж, өгүүлэлт зохиолыг гүн ухааны аяс, сэтгэмжийн түрлэг, хөгжимлөг эгшиглэнтэй болгож

чадсан юм. Яг нарийн хэлбэл, өгүүллэгийн ур чадвар, төрөл зүйлийн бичлэгт яруу найргийн сэрэл, сэтгэмж, мэдрэмжийг зөв ашиглан идээшүүлж чаджээ.

Уянга гэдэг бол хүний сэтгэлийг хайлгах нандин гоо сайхан бөгөөд нарийн авиа аялгуут хөгжмийн адил эгшиглэнт чанар мөн боловч, дан ганц зохист аялгуу ч биш. Ерөөс хүний сэтгэлийн утсыг хөндөж өрөвдөх, хайрлах, жигших, эмзэглэх, үзэн ядах, бишрэх, харамсах, халаглах, ухаарах, хилэгнэх, харуусах зэрэг сэтгэлзүйн түмэн өнгө хувирлыг гаргахыг хэлж байгаа бөгөөд, ингэж чадсан юм. С. Эрдэнэд өөрт нь яруу найргийн эмзэг торгомсог нөлөөлөл, эрчим хүч, дотоод цохилготой хөдөлгөөнийг тусган ойлгох увидас шид байсан нь дундачаас илүүтэй гэж үнэлж болохоор анхны бүтээл “Тал нутгаар явахдаа”, “Хаврын уянга” зэрэг яруу найргийн бүтээлээс харагддаг. Хэрвээ түүнд шүлэгчийн ийм билэг авъяас байгаагүй бол өгүүллэг нь уянгын нэгэн айзам хэмнэлээр дутах байсан шиг санагддаг.

Зөвхөн гадаад талын гялбасан өнгө биш, баатруудын хэл яриа, бодол санаа, дотоод сэтгэмж, сэтгэлзүйг өөрчилж чадсан байна. Дан ганц уянгаар хол явахгүй энэ бол зөвхөн хийл хөгжимтэй адилтгавал, утасны ганцхан чавхдас л юм. Үүн дээр гүн ухаан, сэтгэмжийг нэмбэл хос чавхдастай болж ая өнгө нь таацан нийцэж мөн чанарын оргилд хүргэх зүйл гэдгийг тэр сайтар ойлгож байв. Нүднээ ил зүйлийг хэн ч ойлгодог. Харин дотор руу өнгийсөн үй түмэн үзэгдлийг нээж сэтгэмж, сэрэхүйг хамтад нь бий болгосноор уран сайхны үнэт зүйл нь тодорхой болно. Уншигчид урансайхны ертөнцийн дотоодод нэвтэрч, сэтгэлийн дур зоргоор уужим орон зайд хязгааргүй хэсүүлэн тэнүүлэх таашаал, урам бахдлыг бий болгож чадсан нь С.Эрдэнийн өгүүллэгийн үнэт зүйлсийн нэг мөн. Энэ нь бараг бүх өгүүллэгт тодорхой харагддаг зүйл тул жишээ авч батлах гэж оролдох нь илүүц юм.

### **С. Эрдэнийн өгүүллэгийн хэл найруулгын үнэт зүйл**

Үнэн чанартаа Монголын өгүүллэгт уянга сэтгэмж авчирсан шинэчлэлийн нөлөөллийг илэрхийлэгч нь чухамдаа зохиолчийн хэл найруулгатай холбоотой. Монгол хэлний үгийн ид шид, үгийн тансаглал, үгийн нээлт, үгийн мэрэмж, үгийн салаа болон үндсэн утга нь ямарч өгүүллэгийн аль ч хэсэгт эрдэнийн сувдан шигтгээ мэт хурц тодоор гялалзаж нэн үзэсгэлэнтэй харагддаг. Үүгээрээ “С. Эрдэнийн найруулга, хэл, хэллэг, хэлц” гэсэн үнэт зүйлийг манай үргэлжилсэн үгийн уранзохиолд цогцлоож чаджээ. Өгүүлэлт зохиолын чадал чансаа гайхамшиг, сүр хүчийн нэг тал нь бүхлээрээ төгс төгөлдөр амьд хэл юм. Нөгөө тал нь дүр босгох, үйл явдлын зөв чиглэл бүхий сонирхолтой уран зохиомж гэж болно. “Хэл муу бол зохиол муу. Зохиол муу бол хэл муу” Энэ бол харьцангуй үнэн биш, туйлын үнэн. Өнөөдөр заримынх нь амнаас хэл яахав чухал биш, асуудал нь хамгийн чухал гэсэн үг хааяа цухалзаж байгаа нь үнэндээ том эндүүрэл, том төөрөгдөл гэдгийг ташрамд тэмдэглэх нь зүй.

С.Эрдэнэ хүн болоод амьтан адгуусыг дүрслэхдээ судас, судсаар нь, хялгас хялгасаар, шөрмөс шөрмөсөөр ширхэгчилэн ялгаруулж, махбодь анатомийн булчин, цогцсын илрэх байдлыг үгийн ид шидээр нэвт сүлбэн дүрсэлдэг бол уул ус байгалийг гэрэл сүүдрийн нягтралыг фото аргаар сарны хөдөлгөөн, нарны тусгал, салхины хувирал, цас шуурганы үймрэл дунд олон өнгөт будгийг ялгаруулан илэрхийлж чаддагаараа дүрслэлийн хосгүй онцлогтой байх юм. Түүний өгүүллэгийн хэл найруулгын үнэт зүйл бол утгазохиолын хэлийг баяжуулсан явдал. Үгийн өнгийг мэдрээд, зохиомжтойгоо зохилдуулж, байранд нь оноож хэлнэ гэдэг бол ёстой эмч хүн мэс заслын хутгыг хэрхэн эзэмшихийн дайтай зүйл мөн.

Их Д.Нацагдорж хөдөөгийн ахуй амьдрал байдлыг нээн харуулдаг бол С.Эрдэнэ мөн адил түүний өгүүллэгийн бараг бүх сэдэв нь хөдөө байдаг бөгөөд Д.Нацагдорж С.Эрдэнийн хувьд “Монгол эх хэлний багш” яах аргагүй мөн хийгээд, түүнээс суралцаж хөлд, хэлд орсон нь “цайны ааг” үнэртэх шиг мэдрэгддэг. Их зохиолч Д.Нацагдоржийн хэлний гайхамшиг бол адилтгал зүйрлэл, чимэг үг, дүр дүрслэлийн үгийг чинээнд нь тултал, хөнөгт сүү юүлж байгаагаар төсөөлбөл, амсарт нь тултал, бүүр дүүрч сагатал нь хэлж чаддагаараа гайхалтай байдаг. Хэдийгээр С.Эрдэнэ өмнөх үеийнхээ алтан гутлыг ч атугай тоож өмсөхгүй байж болох ч хэлний илэрхийллээс суралцах нь хуулбарлах явдал биш, тэлэн хөгжүүлэх явц юм.

Ганцхан зүйл жишээ хэлэхэд, “Хулан бид хоёр” өгүүллэгийн Хуланг ингэж дүрсэлжээ. “Хулан хүүхэн өлмийг хотойлгон жижүү дөрөө жийж, хөх торгон тэрлэгний хормойг өвдөгнөөсөө дээш цугларуулж, торгон оймсны цаана туяарч байгаа чийрэг булчингаа чангахан ороож, боржигон хийцтэй эмээл дээрээ янзтайхан сууж, шар дурдан бүс эвлэгхэн ороосон нарийхан бэлхүүсээ жороо хүрнийхээ явдлын аясаар үл мэдэг нахилзуулан явна” гэж дүрсэлсэн байна. Үүнийг Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэнгийн” Санбэйсийн наадамч бүсгүйн байдалтай зэрэгцүүлэн үзвээс үндэсгүй мод, үзүүр ёзооргүй хад чулуу байдаггүйг харуулна. “Энгэр нударгыг хар торгоор эмжиж, нарийхан хошмог тавьсан хүрэн ягаан чисчүү дээлийг өмсөн, зүүн ханцуй дотроос нарийхан хурууг цухуйлган жолоо цулбуурыг хугас атгаад баруун ханцуйгаа сул тавин, түүний дотор гараа нуун, ташаагаа тулж, буулгасан том нударгыг далбайлган бүрхүүлсэн нь шинэ цагийн хээнцэр байдлыг гайхуулжээ. Хоолойн товчийг задгай тавьсаны дотуур бас хар торгоор бөөрөнхийлөн эмжсэн цайвар шар дурдан цамцны зах цухуйж, түүний дотор нимгэн цагаан хөрстэй гуа хүзүү үзэгдэхэд хазаад авмаар...” гэж морь унасан хөдөөгийн хоёр сайхан монгол залуу хүүхний хөрөг зураг манай хоёр том зохиолчийн өгүүллэгт ингэж мөнхөрчээ.

Жинхэнэ монгол ахуй монгол хэлний алт мэт тунгаамал шижрийг тунаруулан туурвисан зохиол бүтээл олон бий. Зохиолч бүр өөрийн өвөрмөц хэллэг, найруулгатай боловч тунгалаг зөөлөн, үнэнхүү бодит зураглал төгс, үй олон утгат ба утгат бус үг, хэлц хэллэг зэргийг зорж сийлсэн мэт нарийн уртай гаргадагаараа эл зохиолч өвөрмөц содон юм. С.Эрдэнийн өгүүллэгийн хэл найруулгын үнэ цэнийг авч үзэж судалъя гэвэл бүхэл бүтэн эрдэм шинжилгээний ажил элбэгхэн болно. Ер нь цаашдаа “С.Эрдэнэ судлалыг” бий болгож, тал талаас нь чамбайруулан судлах нь манай өнөөгийн утга зохиолын хөгжилд ач тустай. С.Эрдэнийн өгүүллэг бүрт гялалзан байдаг өнгөт болрын талст шиг хэллэг нь түүний идэр залуудаа зохиосон ” Алтан өргөө” киноны Лусын хааны баян тансаг орд өргөөний эргэн тойронд дахь эрдэнийн чимэг сондортой адил төстэй юм.

### **С.Эрдэнийн туурвилзүйн гүн ухааны үнэт зүйл**

С. Эрдэнэ зохиолчийн сэтгэлгээ, сэтгэмж нь яв явсаар ертөнцийн явдлыг танин мэдэх гэсэн гүн ухааны аясыг бий болгож, эгэл ардын амьдралын гүн ухаан тэр чигээрээ яргаж оршссон байдаг. Харих цагийн ёс, насны доройтол, үхэл ба амьдрал гэвч түүнд бууж өгөхгүй ухаан тэмцэл, амьдралд тэмүүлэх чанар, цаг хугацаатай богино амьдралын гүн дэх шунал, эрт эдүгээг зэрэгцүүлэн гүн гүнзгий үзүүлдэг. Мугуйд явдлын эсрэг сэтгэл өвдсөн шаналал чамгүй тохиолддог. Энэ их хөгжил хөдөлгөөн малчны олон зуун жил идээшин дассан газар шороог эвдэн сүйтгэж, цаашилбал язгуур угсаа, түүхт зүйл, хүнлэг ёс руу дайрч хэмхчиж байгааг “Өвгөн хүн чулуу хоёр” өгүүллэгтээ нарийн тусган гаргасан нь чухамхуу өнөөдрийн байгаль руугаа



шунахайран довтолж байгаа хомхойрол цэвдэгшлийг ихээхэн зөн билэгтэйгээр төсөөлж өвгөн Ёнхорын уур цухлаар илэрсэн гүн ухаан байдаг. Ерөнхийдөө түүнийг өгүүллэгийг бүхэлд нь авч үзвэл, хүмүүний амьдралын гэрэл сүүдрийг эргэцүүлсэн гуниг, цухал, гутрал, зовнил, сэтгэлийн шарх түлхүүтэй байдаг гэж болно. Зохиолчийн сэтгэлдээ эдэлж явсан зовиур, шаналлыг зохиолоос нь таньж мэдэж болмоор байна.

Энэхүү нэрлэн дурдаж байгаа “Өвөгцүүл”, “Диваажинд хүрэх оньс” “Өвгөн чулуу хоёр” “Өвгөн шувуу” зэргээс гүн ухаан мэдрэгддэг. Гүн ухаан гэхлээр хэт маяглал, хэт хийсвэрлэл, хэт гаднын философийн гуйланчлал, хэт хуурам худал янзын сэтгэлзүйн богино тачирхан бодлого бишээ. Ер сүржигнэхгүйгээр, ер номчирхохгүйгээр амьдралын хөрсөн дээр зогсож, эргэн тойрноо дүнсгэр чимээгүй байдлаар бодлогоширон харж, тэрхүү ойлгомжгүй зүйлийг доторлож хэлж чадаж байгаа нь гүн ухааны үнэт зүйл юм. “Өвгөн шувууны” Жав өвгөн яалт ч үгүй хорвоогоос буцахын өмнөхөн нэгэн голын багын найз өвгөчүүлээ цуглуулж, эрүүл хүн шиг үгээр даажин тохуу хийж сэтгэлээ сэргээж, гэмээ цайруулаад, гэрийнхээ гадаа адуугаа хураан авчруулж түүнийг харан баясаж, амьдралаас салах ёсыг гүйцэтгэж байгаа нь өр цөмрөм агуу эмгэнэл төдийгүй, монгол гүн ухаан юм. Энэ мэт энгийн хэрнээ энгийн бусаар хүнд нэгийг бодогдуулж, ертөнц авхайн хоосон мөн чанарт нэвчихийг анзаарч эрмэлзэж ирснээрээ С.Эрдэнэгийн бүтээл содон сонин онцгой байна.

### **С.Эрдэнийн дүрийг босгох эрэл хайгуулын үнэт зүйл**

Хүн гэж чухам хэн бэ? гэдгийг бие болоод сэтгэлзүйн төвшинд гаргаж тавьсан. Олон олон өгүүллэгтээ монгол өвгөдийн дүрийг гаргажээ. “Өвгөдийг дагаж ухаан, уулыг дагаж горхи” гэж үзвэл монгол ухааныг л эртний уламжлалт сэтгэлгээнээс эрж, яаж илэрхийлэх вэ? гэсэн уран бүтээлийн эрэл хайгуул мөн байна. Өөрөөр, дүрийн хувьд эмэгтэй хүний царай зүс, сэтгэлийн гоо сайхныг бишрэн түүнийг алдаршуулан дуулсан дүр бишгүй тохиолдоно. Түүний өгүүллэгийн эмэгтэйчүүд газар тэнгэрээс тасарсан хорвоод хосгүй гоё ховор амьтад бишээ. Хамгийн эгэл энгийн хаа ч тааралддаг, хаа ч байж л байдаг тэр хүмүүс юм. Хүн хүнээс онцгой тасарсан эрдэм чадалтай, үлгэрийн дагина мэт үзэсгэлэн гоо биш, хөдөөний гол ус, малын бэлчээр дагасан жирийн бүсгүйчүүдийн сэтгэлийн далд гоо сайхан байдаг. Гэвч тэр эгэл бусыг гоо сайхнаар нээснээр эгэл бүсгүйчүүл эгэл бус бурханлаг ид шидтэй болдог чанарыг нээсэн. Ингэснээрээ “Занабазар” романыг бичсэний адилаар өндөр гэгээнтний бүсгүй хүний дагиналаг чанарыг нээн харуулж дүрслэх урлагт мөнхөрсөн бол С.Эрдэнэ үгийн уран, билгийн нүд, сэтгэлийн тольтоороо бүсгүй хүнийг урласнаараа өндөр гэгээнтэн Занабазарын дараачид орохуйц уран дүрийн хосгүй урлаач гэж ч болох юм. Эгэл жирийн гоо сайхан гэдэг бол энэ бөгөөд хүн сэтгэлээрээ, жирийн байдлаараа гоо сайхан байх ёстойг сануулж байна.

Зохиолч амьдралын энэрэнгүй үзэлтэн гэдэг нь өгүүллэг бүрт дүрслэгдсэн бүсгүйчүүд ямар ч хар буруу санаагүй, уян зөөлөн, гэнэн дурламхай, дур булаам, энхрий ялдам байдагт оршино. Зохиолч өөрөө “Монгол бүсгүйн аль ч эрхэм чанар буюу догшин ноён хутагт Равжаагийн “Үлэмжийн чанарт” гардаг бүх нарийн нандинг би зөвхөн хөдөөгийн хүүхнүүдэд бийгээр төсөөлөн боддог” гэж хэлсэн билээ.

### **Зохиолч - байгалийн амьтан болох зүй тогтлын үнэт зүйл**

Байгаль, хөдөөгийн буйд амьдрал ахуй бол С.Эрдэнийн уран бүтээлийн салшгүй нэгэн хэсэг агаад амьдралын туршид түүний нууцыг тайлах гэсэн эрмэлзэл нь танин мэдэхүйн мөнхийн дагуул болжээ. Зохиолчийн уран сайхны сэтгэлгээний нэг гол цөм

нь байгаль гэж болно. Байгаль хүн хоёрыг ямагт холбоотой авч үзэж, учир шалтгаалцалтай хүн байгалийн амьтан гэдэг санааг тусгаж дүрсэлж ирсэн нь түүний өгүүллэгийн бас нэгэн үнэт зүйл мөн. “Говь гэмээн говь билээ”, “Хангай”, “Алтай”, “Миний эх орон-миний тоонот” “Зүүдний цагаан унга” зэрэг байгалийн гоо сайхныг бишрэм гоёмсогоор дүрсэлж, байгалийг хайрлах, эх орноо хайрлах сэтгэлийг хамгийн эмзэг, хамгийн яруу тодоор илэрхийлсэн зохиолч бол Сэнгийн Эрдэнэ юм.

Байгалийн гоо сайхнаас ургуулан уран бүтээлийн дүрслэлийн нээлт ч хийсэн. *“Ховд голын хөндийд намуухан шар салхи сэмхэн хэсүүчилж байхад, тэртээ өндрийн хадан цохионд хар салхи, Цамбагаравын хяр оройгоор бол дун цагаан салхи салхилж байв”* “Чулуут голын цуурайг сонсож, Эгийн давааны орой дээрээс *“Хоёр хангайн нутаг хүрэнтэж найгахыг” харж явсан залуу насанд санах хүнтэй явж дээ. Хангайн намар модны навч шарлан, шувуу сүрээглээд ирэхээр “Ай хөөрхий намар боллоо доо” гэж сэтгэл хачин дэнсэлнэ*” “Ганга нуурын ганган улаан бургас ганхаж байхыг үзсэн цаг амьдралын их олз мэт санагдан Тоорой бандийн домогт Шилийн Богд, талын дунд асарлан цэнхэрлэхүйд монгол хүн оршин амьдарсан цагаас энэ гэрэлт дуулим тал минь хичнээн юм үзээ болоо гэх зэрэг олон юм бодогдсон доо” гэхчилэн нарийн мэдрэмжийн мөрүүд бол байгаль болоод түмэн бодисын нууц, түүний чимээ аниргүйхэн мөртлөө сүрлэг шинж, давтагдашгүй хөг аялгууг нээж улмаар монгол хүмүүн эх орныхоо төлөө цохилох зүрх сэтгэлтэй байх ёстой гэдгийг онцгой товойлгосноороо өвөрмөц юм.

Монгол Улсын Ардын уран зохиолч, Төрийн шагналт Сэнгийн Эрдэнийн нэн ялангуяа богино өгүүллэгийн ур чадвар, өгүүлэхүйн чадал чансаа, амьдралд нэвтэрсэн гүн ухаан, монгол хэлнийхээ үгийн уурхайг эзэмшсэн бичгийн найруулга, ертөнцийг өөрийнхөөрөө төсөөлж дэвшүүлж тавьсан санаа туурвилын үнэт зүйлс хэдэн зууны туршид бүдгэрэхгүй, урлахуй ухааны ариун гэгээн өлгий Сэрүүн дуганын хөх зөнт сүмийн алтан ганжир мэт тэртээ холоос гялалзан харагдсаар байна гэдэгт өчүүхэн эргэлзэх юм алга.

**Улаанбаатар 2009 . 11. 21- 22 Бямба, ням гариг.**

## SUMMARY

In this article, the author studied what are the values of literary works with a new research method and explained them on the example of S.Erdene's short stories. It attracts the researchers' attention as literary phenomenon. By analyzing the works of S.Erdene, the author considered that S.Erdene brought innovation and changing to the Mongolian literature.